



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 247

Улаанбаатар хот

Биет бус хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 2.1, 2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын Стратеги, бодлого, инновац, хөгжлийн алба (хуучнаар Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба)-ны биет бус хөрөнгөд бүртгэлтэй, 3271 метр квадрат талбай бүхий, нийт 72,576,960.00 (далан хоёр сая таван зуун далан зургаан мянга есөн зуун жар) төгрөгийн балансын үнэтэй хавсралтад заасан биет бус хөрөнгө (газар эзэмших эрх)-ийг данснаас хасч, цэцэрлэгийн зориулалтаар ашиглуулахаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдэлд шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Цагдаагийн ерөнхий газрын дарга, бригадын генерал Т.Сүхболд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө данснаас хасах, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

133001333

12-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 14 дугаар сарын 28-ны өдрийн
28 дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН СТРАТЕГИ, БОДЛОГО, ИННОВАЦ, ХӨГЖЛИЙН АЛБА
(хуучнаар МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБА)-НЫ
БИЕТ БУС ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ДАНСНААС ХАСАХ, БҮРТГЭЛД ТУСГАХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Бүртгэсэн он	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Хэм жиж нэгж	Тоо шир хэг	Балансын нийт үнэ (төгрөг)	Бүртгэлд тусгах хуулийн этгээд
1	Биет бус хөрөнгө (газар эзэмших эрх, нэгж талбарын дугаар-1461601676), Сүхбаатар дүүрэг, 11 дүгээр хороо	2022	22,188.00	м2	3271	72,576,948.00	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
	Нийт дүн					72,576,948.00 (далан хоёр сая таван зуун далан зургаан мянга есөн зуун дөчин найм)	